

С.Хүрэлсүх¹✉

¹ ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Эртний нүүдэлчдийн ташууртай холбогдох олдворууд

Товчлол. Нүүдэлчид нэн эрт цагаас адууг уналга эдэлгээнд хэрэглэх явцдаа хэрэглээний онцлогт тохирсон олон төрлийн тоног хэрэгслийг бүтээн бий болгож, хөгжүүлэн уламжилсаар иржээ. Тэдгээр бүрдэл хэсгийн нэг нь ташуур юм. Ташуурын ишийг ширхэг нягт модоор, сагалдарга болон зангиаг сураар хийдэг уламжлалтай. Археологийн судалгаагаар эртний чулуун дарааст булшнаас ташууртай хамааралтай олдвор олоод байх нөхцөл тун бага ч нүүдэлчдийн өөр нэг оршуулгын өвөрмөц хэлбэр болох хадны оршуулгаас ташуурын мод илэрсэн хэд хэдэн тохиолдол байдаг. Эдгээр олдворт тулгуурлан адууны тоног хэрэгслийн нэг ташуурын талаар өгүүллээ.

Түлхүүр үг: Эртний нүүдэлчдийн ташуур, дундад зууны үед ташуурыг уран зургийн дурсгалд дүрсэлсэн нь, ташууртай холбогдох зарим зан үйл.

S.Khurelsukh¹✉

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

A Horse whip found an Ancient Nomadic Burials

Summary. This is article ancient nomadic whip. From time immemorial, nomads have used and developed a variety of equipment to suit the specifics of their use of horses for riding. One of them is a whip. The whip is traditionally made of solid wood with a strap and a tie. Archaeological excavations have shown that whip-related artifacts have been found in ancient tombs, but there have been a number of cases where whip trees have been found in rock burials, a unique form of nomadic burial. Based on these findings, a whip, a type of horse equipment, is described. According to the materials the ancient whip tree was found in 1 stone tomb from the Xiongnu period, 1 from the related rock burials in the Ancient Turkic period, 4 from the rock burials in the Great Khitan state, 3 from the Mongols period rock burials, and a total of 9 items were artifacts.

Keywords: *The whip of the ancient nomads, The whips found in rock burials*

Удиртгал

Нүүдэлчдийн бий болгосон мал аж ахуйн соёл тэр дундаа адууны уналга эдэлгээтэй холбогдсон тоног хэрэгсэл хэдэн мянган жилийн турш хэрэглээнд байж, улам боловсронгуй болсоор эдүгээг хүрсэн бөгөөд адууг эртнээс монголчууд өдөр тутмын ахуйгаас эхлээд ав хоморго, аян дайн, нүүдэл суудал, уналга ачилга, өртөөний алба зэрэг аль болох хурдан түргэн явдалд өргөн ашигласаар ирсэн нь тэдний амьдралын салшгүй нэгэн хэсэг болж, адууны арвин баялаг өв соёл буюу ногт, хазаар, эмээл, тохом, хударга, хөмөлдрөг, дөрөө, ташуур, чөдөр зэргийг бүтээн бий болгожээ.

Энэхүү баялаг өв соёлыг илтгэх олдворууд булш, оршуулгын дурсгалд урт удаан хугацаанд хадгалагдсан эмээлийн мод, дөрөө, хазаар зэргийг судлаачид түлхүү авч үзэн тодорхойлсон нь тохиолдох бөгөөд ташуурыг зөвхөн нэр дурдах төдийгөөр судалгааг нь орхигдуулж иржээ хэмээн үзэж болно. Энэ нь нэг талаар аргагүй шалтгаантай. Учир нь “органик” гаралтай материал буюу мод, сураар хийсэн ташуур нь хөрсөнд хэдэн зуун, мянган жилээр удаан хугацаанд хадгалагдан үлдэх боломжгүй тул булшнаас тэр бүр илэрч олдоод байх бололцоо багатай. Нөгөө талаар хөрсөнд үйлдсэн булшны эд өлгийн зүйлс нь олон жилийн халалт, хөрөлт, чийг зэрэг байгалийн нөлөөнд багагүй автдаг тул модны мөчрөөр хийсэн ташуур дийлэнхдээ ялзарч үлдэж хоцордоггүй. Тиймээс онцгой ховор тохиолдолд ташуурт хамаарах үлдэгдэл төдий олдворыг судлаачид ялган таниад, баримтжуулан тодорхойлно гэдэг бас их анхаарал, туршлага шаардсан ажил юм.

Харин хадны оршуулгын дурсгалын өвөрмөц орчин нөхцөлд ямар нэгэн олдворууд тэр дундаа мод, мал, амьтны гаралтай арьс, шир, үс, ноос, нэхмэл бөс, төмөрлөг материалаар хийсэн эд өлгийн зүйлс байгалийн нөлөө бүхий өгөршилд харьцангуй бага өртөж, маш сайн хадгалагддаг онцлогтой. Тиймээс хадны оршуулгын хэд хэдэн дурсгалаас ташуурын мод илэрсэн бөгөөд энэ удаа археологийн биет олдворт тулгуурлан эртний нүүдэлчдийн агт морины нэгэн хэрэгсэл болох ташуурын талаар тусгайлан өгүүлэхийг зорилоо.

Археологийн олдвор

Эртний нүүдэлчдийн булш оршуулгын дурсгалаас агт морины тоног хэрэгсэл тэр дундаа хазаар, эмээл, дөрөө, хөмөлдрөг, хударга ихэвчлэн илэрч гардаг хэдий ч морь унахад эдгээрийн адил багагүй үүрэгтэй ташуурын мод илэрсэн нь их цөөхөн. Өмнө дурдсанчлан ташуурыг модны мөчир, нарийн сур ашиглан хийдэг тул хөрсөнд удаан хадгалагдах боломж ихээхэн хязгаарлагдмал юм. Гэсэн хэдий ч монголчуудын өндөр өвөг хүннүчүүдийн чулуун дарааст булшнаас илэрсэн цор ганц гэж үзэж

болох тохиолдол бий. Тухайлбал, Ховд аймгийн Булган сумын нутаг Авын Хөх уулын хүннүгийн 20-р булшны малтлагаар 190 см гүнд оршуулга илэрсэн ба хүний ясны хөл талд хоёр шилбэний завсар ташуурын модыг тавьсан [Төрбат нар 2015: 305] байсан ба олдворын тодорхойлолт хэсэгт “ташуурын мод 11 хэсэг болсон ба хадгалалт муу. Хоорондоо эвээрээ нийлнэ. Нэг үзүүрээс 1 см орчим жижиг булцуутай ба хөндлөн гаргасан нүхтэй. Нүхний голч 0,2 см. Эвлүүлсэн үеийн урт 38,3 см, голч 0,9 см” (зураг 1а) хэмээн дурджээ [Төрбат нар 2015: 307].

Эртний нүүдэлчдийн оршуулгын өөр нэгэн хэлбэр болох хадны оршуулга нь нар үзэхгүй, чийг орохгүй хуурай, сэрүүн нөхцөлтэй байж агаарын солилцоог нэгэн зэрэг хангаж өгдөг байгалийн өгөгдөлтэй гэж ойлгож болно. Хадгалалтын нэн таатай ийм орчинд маш сайн хадгалагдсан ташуурын мод хэд хэдэн оршуулгаас илэрчээ. Тухайлбал, Жаргалант Хайрханы оршуулгаас олдсон “ташуурыг модны мөчир бололтой, холтослоогүй урт нарийн модоор хийсэн. Модны хоёр үзүүрийн төгсгөлийг мөлийлгөн зассан. Бариул хэсэгт нэвт цоолж гаргасан нүх буй нь сагалдарга уяхад зориулсан. Сурын үлдэгдэл хадгалагдаж үлдээгүй. Энэхүү ташуур гурван хэсэг болж хугарсан байх боловч эвээр нь нийлүүлэхэд бүтэн болно. Ташуурын урт 100,6 см, өргөн 1,1 см хэмжээтэй” (зураг 1б) [Батсүх нар 2014: 236].

Арцат Дэлийн хадны оршуулгаас “нарийн үзүүртээ хугархай, засаж боловсруулаагүй модны мөчрөөр хийсэн ташуур илэрсэн. Нэг үзүүртээ сагалдаргын сур оруулах амсрыг нь томгосон нүхтэй. Бариул хэсэгтээ давхар ороосон сурын үлдэгдэлтэй. Ташуурын урт 53,5 см урттай” (зураг 1в) [Эрдэнэбат нар 2005: 85]. Дугуй Цахирын хадны оршуулгаас “бургасны мөчрөөр хийсэн ташуурын үлдэгдэл илэрсэн. Нэг үзүүр бяцарч гэмтсэн. Нөгөө үзүүр буюу бариулын хэсгийн төгсгөлийг гурвалжлан засаж, сагалдаргын оосор сүвлэн оруулах нэвт нүх гаргасан нь 0,6 см голчтой. Ташуурын урт 60,2 см, бүдүүн нь 1,5 см” (зураг 1г) [Эрдэнэбат нар 2010: 35].

Үзүүр Гялангийн оршуулгаас илэрсэн “ташуурыг бургас модоор хийсэн. Бариул хэсэгтээ сагалдаргын нүхтэй, гол хэсэгтээ 2-3 үе ороосон нарийн сурын үлдэцтэй. Урт 91 см хэмжээтэй” (зураг 1д) [Энхтуяа 2017: 47]. Чонот уулын оршуулгаас илэрсэн “ташуурыг сухай модоор хийсэн. Урт 36,8 см, өргөн 0,94 см. Бариул болон үзүүр хэсгийг зорьж тэгшилсэн. Бариул хэсэгт сагалдаргын сур сүвлэх нэвт нүх гаргасан бөгөөд уг нүхэнд хатсан сурын үлдэгдэлтэй” (зураг 1е) [Turbat et al. 2012: 282]. Хагтын оршуулгаас илэрсэн “ташуурыг харавтар өнгийн нарийн бургасаар хийсэн. Хоёр үзүүрийг зорьж дугуйлан

ирмэгийг дарсан. Бариул хэсэгт сагалдаргын нүх гаргасан. Урт 30,8 см, голч 1,7 см хэмжээтэй” (зураг 1ө) [Амартүвшин нар 2020: 121].

Цагаан хадны оршуулгаас илэрсэн “ташуурын мод нь далийж мурийсан зүйлгүй шулуун ба 38,8 см урт, 1,8 см өргөнтэй. Хоёр үзүүрийг ирмэглэж зассан. Бариул хэсэгт сагалдаргын нүх гаргасан бөгөөд эндээ сурын үлдэгдэлтэй” (зураг 1з) [Ahrens et al. 2015: 96].

Өндөр Хүрэний хадны оршуулгаас илэрсэн ташуур [몽골의 문화 유산 2010: 77] нь бариул хэсэгтээ сагалдаргын сур оосорлох нүхгүй, харин модны үзүүр хэсэгт “булцуу” гарган түүнийхээ дор залгуулан ховил гаргасан. Энэ тээглүүр бүхий нарийн ховил хэсэгт сагалдаргын сурыг бэхэлж уядаг байжээ. Уг ташуурын модонд сагалдарга болон сурыг холбож уясан нь тэр чигтээ зангилаатайгаа үлджээ (зураг 8а). Урт 33 см, өргөн 1,2 см, сагалдаргын сурыг торгоох булцуу 2 см өргөнтэй, нарийн хүзүү 0,8 см хэмжээтэй (зураг 1ж).

Эдгээр археологийн олдвороос үзэхэд хүннүгийн үеийн чулуун дарааст булшнаас ташуурын мод илэрсэн нь тун ховор тохиолдол юм. Ташуурын иш буюу нарийн урт мод хоёр мянган жилийн хугацаанд хадгалагдан өнөөг хүрсэн нь Алтайн нурууны өндөрт орших цэвдэгтэй бүс нутаг археологийн олон дурсгалыг маш гайхалтай хадгалагдаж үлдэх нөхцөл болж байжээ. Бусад ташуурын мод хадны оршуулгаас илэрсэн бөгөөд ташуурын ишинд сагалдаргын нүх гаргасан байх ба зарим тохиолдолд сагалдаргын сурын үлдэгдэлтэй, зарим нь суртайгаа илэрчээ. Эдгээр 9 олдвороос гадна ташууртай холбогдох зарим лавлах хэрэглэгдэхүүн бий.

Манай улсын нутгаас илэрсэн дээрх олдворуудаас гадна БНХАУ-ын баруун хойд бүс нутаг болох Шинжааны хэт хуурай, бараг бороо ордоггүй элсэн цөл бүхий Турфан хотын орчимд байх Янхай-I оршуулгын газарт 218 булш, Янхай- II оршуулгын газарт 223 булш

малтан шинжилсэн байх ба зарим булшнаас нь тун сайн хадгалалттай цөөн хэдэн ташуур болон ташуурын мод илэрчээ (зураг 3а-и) [新疆洋海墓地 2019: 30, 38, 45, 97, 115, 238, 280, 366]. Эдгээр олдвор нь хэдэн мянган жилийн хугацаанд тун сайн хадгалалттай байгаа нь чийггүй хуурай уур амьсгалтай бүс нутгийн элсэн манханд тавьсан оршуулга учраас булшинд дагалдуулсан эд өлгийн зүйлс нь байгалийн хүчин зүйл бүхий өгөршилд авталгүй тэр хэвээрээ хадгалагджээ. Янхай-I оршуулгын газрын булшнуудаас илэрсэн ташуурын модыг манай улсын нутгаас илэрсэн ташуурын олдворуудтай харьцуулан авч үзэхэд ерөнхийдөө ойролцоо хэлбэр хэмжээтэй байна. Тухайлбал, 11-р булшнаас илэрсэн ташуурын ишний урт 31,8 см урт, 1,3 см өргөнтэй [新疆洋海墓地 2019: 29], сагалдаргын сурыг мөн адил ишний үзүүр хэсэгт нүх гарган тогтоож, нарийн уртавтар сур унжуулжээ (зураг 3а).

Энэ бүс нутаг цөлөрхөг элсэн манхан ихтэй учир магадгүй адуунаас гадна тэмээ зэрэг бусад амьтдын уналга эдэлгээнд доорх ташууруудыг ашиглаж байсан байх. Учир нь Янхайн соёлыг үлдээгчдийн зарим хэсэг нь хагас нүүдэлчид бөгөөд булшны малтлагын тайлангаас үзэхэд ташуурын олдвортой нүүдэлчдийн гол илэрхийлэл болох эмээл хамт илэрсэн тохиолдол тэмдэглэгдээгүй байдаг.

Уран зургийн дурсгалд ташуурыг дүрсэлсэн нь


Бунхны ханын зурагт. Хятаны бунханд оршуулгад бусад цаг үеийн булшны адил талийгаачийн эдэлж хэрэглэж байсан хувцас өмсгөл, гоёл чимэглэл, сав суулгын зүйлсийг дагалдуулан тавьдаг ч хамгийн сонирхолтой нь бунхны хананд баялаг агуулга бүхий өнгө ялган будсан зураг зурсан байдаг ажээ. Ханын зурагт талийгаачийн зэрэг зиндаа, амьд ахуйдаа ямар үйл хэрэг эрхэлж байсан, нутаглаж байсан газар ус, ахуй амьдрал, ан ав, аялал зугаалга, хувцас

Хүснэгт 1. Ташуурын мод илэрсэн оршуулгуудын олдсон газар, холбогдох он цаг


№	Дурсгал	Олдсон газар	Холбогдох он цаг (C14)
1	Авын Хөх уулын 20-р булш	Ховд, Булган	НТӨ 43 – НТ 89 он
2	Жаргалант Хайрхан	Ховд, Манхан	590-670 он
3	Арцаг Дэл	Баянхонгор, Бөмбөгөр	950-иад он
4	Дугуй Цахир	Баянхонгор, Баянцагаан	992-1146 он
5	Үзүүр Гялан	Ховд, Мөнххайрхан	X зуун
6	Чонот уул	Ховд, Булган	1020-1210 он
7	Хагт	Баян-Өлгий, Алтанцөгц	1271-1290 он
8	Цагаан хад	Өвөрхангай, Богд	1300-1370 он
9	Өндөр Хүрэн	Говь-Алтай, Чандмань	1330-1410 он

Хүснэгт 2. Ташуурт хамаарах олдворын харьцуулалт, ангилал

№	Олдвор	Модны төрөл	Ташуурын урт	Сагалдаргын нүхтэй эсэх	Ангилал
1	Авын Хөх уулын 20-р булш	-	38,3 см	байгаа	дундаж
2	Жаргалант Хайрхан	бургас	100,6 см	байгаа	урт
3	Арцат Дэл	яргай	53,5 см	байгаа	урт
4	Дугуй Цахир	бургас	60,2 см	байгаа	урт
5	Үзүүр Гялан	бургас	91 см	байгаа	урт
6	Чонот уул	сухай	36,8 см	байгаа	дундаж
7	Хагт	бургас	30,8 см	байгаа	богино
8	Цагаан хад	сухай?	38,8 см	байгаа	дундаж
9	Өндөр Хүрэн	яргай	33 см	байхгүй	дундаж



Зураг 1. а. Авын Хөх уулын хүннү булш, б. Жаргалант хайрхан, в. Арцат дэл, г. Дугуй Цахир, д. Үзүүр Гялан, е. Чонот уул, ё. Хагт, з. Цагаан хад, ж. Өндөр Хүрэн зэрэг оришуулгаас илэрсэн ташуурын моднууд




Зураг 2. Ташуурын моднуудын бариул хэсгийн үзүүрт сагалдаргын сур сүвлэх нүхийг гаргасан ба зарим нь сурын үлдэгдэлтэйгээ. Өндөр Хүрэний оришуулгаас илэрсэн ташуурын модонд “булзуу” гарган нарийн хүзүү хэсэгт нь сагалдаргын сурыг уяж байсан ажээ.

өмсгөл, хоол хүнс, тоглоом наадгай зэрэг олон сэдвийн хүрээнд ердийн нэг бодит дүрслэл байхаас гадна маш өргөн гүн агуулгатай зургийн дүрслэл ч байдаг. Өөрөөр хэлбэл зарим бичгийн сурвалжид тэмдэглэсэн мэдээ, баримтыг нүдээрээ харж мэдэх боломж нээгддэг. Тиймээс түүхийн дутмаг талыг нөхвөрлөх, сурвалжийн мэдээг нягтлан үзэх, бичгээр тэмдэглэгдэж үлдээгүй

зарим зүйлийг тодорхой үйл явдалтайгаар зургаар харуулсан чухал эх сурвалж болдог ажээ [Баянтал 2021: 106].

Нүүдэлчидтэй гарал угсаа нэгтэй хятанчууд адууг уналга эдэлгээнд өргөн хэрэглэж байсныг бунхны ханын зургаас харж болох бөгөөд эзнээ ан ав, аян жинд явах үед нь унаа морийг нь хазаар, эмээл, тохом, дөрөө, ташуур, хөмөлдөрөг, хударга



Зураг 3. Янхай-1, II оршуулгын газрын цөөн хэдэн булингуудаас илэрсэн ташуурт хамаарах олдворуудын гар зургууд

бүхий иж бүрэн хэрэгслийн хамт бэлтгэдэг байна. Тухайлбал, Уухан хошууны бунхны ханын зурагт гэзэг үс болон дээл хувцсаараа яах аргагүй хятаан хүн болох агтчин суран сагалдарга бүхий хоёр үзүүрийг өргөн эмжсэн, барагцаагаар 1 м орчим урттай, бүдүүвтэр ташуурыг баруун гартаа, зүүн гартаа морины жолооноос барин зогссон (зураг 4а) [Баянтал 2021: 163], эзэн ажил, албаны хэргээр явах гэж буй сэдэвтэй дараагийн зурагт ойролцоогоор 80 см орчим урттай, нарийн мөчрөөр хийсэн ташуурыг агтчин баруун гартаа гол хэсгээс

нь барьсан байх ба уг ташуур сагалдаргагүй, хооронд нь 20 см орчим зайтайгаар нарийн сураар бөгжилсөн байна (зураг 4б) [Баянтал 2021: 161], ан авын сэдэвтэй сүүлийн зурагт сагалдаргагүй, барагцаагаар 80 см урттай, нарийн мөчрөөр хийсэн ташуурыг агтчин доод үзүүр хэсгээр нь зүүн гараараа барьж зүүн мөрөндөө тэгнүүлэн босгосон байдлаар дүрсэлжээ (зураг 4в) [Баянтал 2021: 148]. Эдгээр зурагт эзний унаа морийг хариуцсан албат болох агтчингуудыг нарийн урт ташуур барьсан байдлаар голчлон дүрсэлжээ.




Зураг 4. а. ӨМӨЗО-ны Уухан хошууны нутгаас илэрсэн бунхны зурагт хятан агтчин сагалдарга бүхий урт ташуурыг баруун гартаа, б. Хүрээ хошууны 1-р бунхны ханын зурагт агтчин ташуурыг баруун гартаа, в. Улаанхадын Уухан хошууны Ламын гуугийн бунхны зурагт ан авд мордох гэж буй эзнийг хүлээж байгаа агтчин зүүн гартаа нарийн урт модон ташуур барьсан байдлаар дүрсэлсэн нь

Эртний Персийн миниатюрт. 1784-1791 онд Стамбулд Пруссийн элч төлөөлөгч байсан Хайнрих Фридрих Дийцийн өвд хамаарах зургийн хэд хэдэн цомог Берлин дэх Улсын Номын санд байдаг байна. Эдгээр зурагт XIII зууны эцэс, XIV зууны эхэн үеийн үйл явдлуудыг дүрсэлсэн тул Иран дахь Монголын Ил хаадын амьдралын тодорхой хэсгүүдийг тухайн цагийн амьд гэрч мэт илэрхийлдэг гэж үздэг [Биргитт Хофманн 2005: 254]. Тухайлбал, “Морьт цэргүүд дайсныг мөрдөн хөөж буй нь” хэмээх зурагт дутаагчдын байдлыг харвал, монголчуудын өөр хоорондын нэгэн тулааныг дүрсэлжээ. Тулалдаанаас дутааж буй дайчид мориндоо ташуур өгч ум хумгүй зугтаж байгаа бөгөөд ташуурыг улаавтар, хар, хар хүрэн, цулгуй зэрэг өнгө ялган давтагдахгүй байдлаар дүрсэлсэн. Түүнчлэн зурагт ташуурыг урт биш богино модоор (жижиг ташуур) хийсэн байгааг харуулах ба бүгд сагалдаргагүй, бариул хэсгээс нь гараар барьсан байдлаар дүрсэлжээ (зураг 5а-д).

“Монгол морьтнууд баривчлагдагсыг авч яваа нь” хэмээх зурагт морьтон бариул хэсэгтээ

нарийн суран сагалдаргатай, бараан өнгийн уртавтар ташуурын доод хэсэгт уртхан сурыг холбож уясан. Сурын нарийн үзүүрийг салаалжээ. Морьтон ташуурын сагалдаргыг гартаа оосорлолгүй, модны бариул хэсгээс барьж, дээш хагас өргөн зангаж ард яваа хүмүүстэй дээрэнгүй байдлаар харьцаж буй нь зургийн үйл явдал өгүүлэмжийг илүү тодорхой болгожээ (зураг ба). “Язгууртан аялж яваа нь” хэмээх зурагт өмнөх зурагтай адил харавтар өнгийн барагцаагаар 40 см орчим урт ташуурыг язгууртан баруун гартаа бариул хэсгээс нь атгасан ба сагалдарга байгаа эсэх нь мэдэгдэхгүй байна. Ташуурын суранд зангилаа гаргасан бөгөөд дээш зангасан байдлаар дүрсэлсэн нь эрх мэдэл бүхий нэгэн гэдгийг илтгэх ажээ (зураг 6б) [Биргитт Хофманн 2005: 272].

“Нэгэн эмэгтэй хаан эзэнд гомдол гаргаж буй нь” хэмээх зурагт хаан бор зүсмийн морь унасан байх агаад зүүн гартаа жолоогоо, баруун гартаа ташуураа барьсан байх аж. Барьсан бараан өнгийн ташууранд сагалдарга байхгүй ба бариул



Зураг 5. а-г XIV зууны монгол морьтон дайчдын өөр хоорондоо дайтсан тулалдааныг харуулсан зурагт ташуурыг дүрсэлсэн нь. Иран, Тебриз хот. Герман Улсын Номын сангийн сан хөмрөг, д. Рашид ад-Диний Судрын чуулганд морьт унасан монгол язгууртныг ташуур барьсан байдлаар дүрсэлсэн нь [https://images.is.ed.ac.uk]



Зураг 6. XIV зууны Монголын Ил хант улсын язгууртнуудыг ажил хэрэг, аялал зэргээр явах үеийг цомогт дүрсэлсэн нь Иран, Тебриз хот. Герман Улсын Номын сангийн сан хөмрөг.

хэсгийн үзүүрт цайвар өнгийн толгой гаргасан байна. Ташуурын бариул хэсгээс нь гараараа барьж, нөгөө үзүүрийг өвдөг дээр тулсан ба зангилаатай сур доош чигээрээ унжжээ (зураг 6в). Эдгээр миниатюр зургуудаас үзэхэд энгийн морьтон дайчдыг богино ташууртайгаар, зэрэг зиндаа өндөртэй язгууртнуудыг нэгэн жигд бараан өнгөтэй уртавтар иштэй модонд сурыг унжуулахдаа зангилаа гаргасан ташууртайгаар дүрсэлжээ.

Ташуурын нэршил, цээрийн ёс, хэлц үг

Ташуур нь морь гуядах хэрэгсэл бөгөөд бургас, яргай, сухай, хулс, зандан, тэнз, сум зэрэг модоор хийнэ. Тухайн хийсэн модоор нь яргай ташуур, сухай ташуур, сураар хийснийг суран ташуур гэж нэрлэнэ. Ташуурын иш – ташуурын яргай, сухай, сур зэргээр хийсэн барих хэсэг. Ташуурын бэрээ ч гэдэг. Ташуурын сагалдарга – ташуурын дээд талд барихад зориулан нарийн сураар хийсэн гогцоо. Ташуурын бөгөлдрөг – ташуурын ишний уг дахь сүвэгч хэсэг. Ташуурын сур – ташуурын доод хэсэгт байрлах суран хэсэг. Ямар ч ташуурын сурын урт 20-30 см-ээс илүүгүй байна. Ташуурын хүлээс, хүлээр – ташуурын сур, иш хоёрыг холбосон уяа (зураг 8) [Энхбаатар 2020: 89].

Ташуурын хэмжээ олон янз байх ба урт бүдүүнийг их гарын, арай бага хэмжээтэйг дунд гарын, 12-20 см урттай модон ташуурыг өдөр тутмын хэрэглээний энгийн жижиг ташуур гэдэг. Түүнчлэн ташуурыг гоёлын, хурдан морины, хүүхдийн, уургын морины гэж ангилдаг [Энхбаатар 2020: 87]. Яргай ташуур гэхэд л халхад Хөгнө хан уулын яргайгаар хийсэн ташуур ихэд алдартай байсан гэдэг. Яргай мод тийм ч элбэг ургадаггүй бөгөөд уулнаас авахдаа гуйж, аргадаж, үр хүүхэдгүй ганц бие хүн авдаг учиртай.

Ташуурыг монголчуудын уламжлалт хэмжээний нэг баримаар хэмжинэ. 3-11 барим хүртэлх хэмжээтэй ташуур хийдэг (зураг 7). Тухайлбал, хурдан морины хүүхдийн ташуурыг гурван

баримаар хэмжиж хийх ба хөнгөн зөөлөн мод болох бургасаар ихэвчлэн хийдэг байна. Яргай, зандан, сум зэрэг мод хурдан моринд хатууддаг. Нэг барим (барагцаагаар 10 см-тэй тэнцэнэ) мод байх ба сагалдарга, мөн сур нэг нэг барим байдаг. Учир нь их урт суртай байх нь уралдаж буй мориныхоо цавийг ороолгох гэмтэй аж. Угаас монголчууд ташуурыг мориндоо урам, цочроо өгөх гэж хэрэглэдэг болохоос бус учиргүй балбаж, олон удаа морио ороолгох нь туйлын зохимжгүй юм. “Ташуур хөдөлгөх” гэж монголчууд ярьдаг нь ташуураа хөдөлгөх төдийд хурдаа нэмдэг адуу байх ба ташуурын сүүдрээр л урагшилдаг гэж ярьцгаадаг. Нөгөө талд нь ташуургүй бол явдаггүй адуу ч бас бий. Заавал ташуур амсаж байж давхидаг гэсэн үг [Энхбаатар 2020: 88].

Харин гоёлын ташуур нь 9-11 барим байх ба мод нь хулс болон яргай гэсэн олдоц ховортой модоор хийдэг. Яргай, хулс, тэнз, суман зэрэг хатуу модоор хийсэн уртаараа 9 барим хэмжээтэй их гарын ташуур нь бөх, үзэмжтэй тул ихэвчлэн гоёлд барьдаг онцлогтой. Мөн гоёлын ташуурын хоёр талыг мөнгөлж, аман хүзүү зангидна.

Монголчуудын зарим баатарлаг туульд ташуурын олон өвөрмөц нэршил бий. Тухайлбал, Баруун Монголд “малиа”, Алтайн Тувачууд “кымчы” гэнэ. Түүнээс гадна яргай болон суран ташуурыг хэрхэн хийх арга технологи болоод содон нэрийг агуулсан туулиуд гэвэл Жангар болон Эрийн сайн хан харангуй билээ. Тэнд:

“Гурван жил хатсан
Элсэн дээр ургасан
Өнчин яргай модоор ишилсэн
Хар тархи гэгч ташуурыг
Баруун гартаа
Базаж атгаад авахад...” [Жангар 1963: 245]
“Гунан үхрийн арьсаар
Гурамслан гөрсөн
Дөнөн үхрийн арьсаар
Дөрөмслөн гөрсөн

Довцог хар ташууртай...” [Эрийн сайн Хан харангуй 1986: 6] хэмээн өгүүлдэг.


Ташрамд дурдахад бурхны шашны зан үйл, ном зохиолд ташуурыг энгийн нэг хэрэгсэл бус талаар хийсвэрлэн өгүүлдэг. Тухайлбал, Чингис хааны тахилга тайлгын соёлд 3 үет хулсан ташуур, зандан ташуур, яргай ташуур гардаг. Монголоос өөр газар сураар гөрж хийсэн ташуур гардаг байна. Нагаржунай буюу Гомбо Лүдүвийн гэгээний зохиосон “Махгал бурхны магтаал зуун найман нэр” хэмээх зохиолд ташуурын тухай хэрхэн бичсэн талаар төвөд судлаач Г.Ням-Очир өөрийн нүүр номдоо товчлон хүргэсэн байдаг. “Гомбо Махгал бурхны хувилгасан зандан ташуурын хөндийгөөс: 84000 тэнгэрийн шар цэрэг (ширэн хуяг өмсөж, хөх туг барьсан), 21000 тэнгэрийн цагаан цэрэг (мөнгөн хуяг өмсөж, хар туг барьсан), 3600 тэнгэрийн улаан цэрэг (зэс хуяг өмсөж, хар туг барьсан), 360 тэнгэрийн бор цэрэг (чон хуяг өмсөж, улаан туг барьсан), 100000 төмөр шанаган

хорхой урьд нь гүйж, 100000 галзуу заан хойноос хашиж, 100000 шар арслан хажуугаар тарж, 100000 төмөр харцага тархинд нь нисэж, 100000 чулуун бүргэд төмөр хумсаа билүүдэж, 100000 салхины хүчит эрчүүд нум сумаа эвшээлгэн гарч ирэн дайсны омгийг дардаг”... хэмээн гарч байна. Энгийн үзэгдэлд ер ташуур мэт харагдах боловч, олон хувилгаан цэргийг хадгалж, хэрэгтэй цагт гаргагч тэнгэрийн эд” хэмээн бичсэн нь ташуурыг энгийн нэг эдлэл бус “тэнгэрийн эд” хэмээн тодорхойлжээ.

Ташуурын тухай цээрийн ёсон. Ташуур барьж айлд орохыг цээрлэнэ. Гийнхүү барьж орвоос танхай балмад гэгдэх буюу гэрийн эзнийг доромжилсонд тооцно. Ташуураа хаа хамаагүй тавихыг цээрлэнэ, ташуураараа хүний зүг зангах дохихыг цээрлэнэ, ташуур тулж тоглох наадахыг цээрлэнэ. Үл хэрэгсвээс унаа мориноосоо сална явгарна гэх буюу унаж бэртэхийн муу ёр гэнэ. Ядравч ташуураа бүү тул зэргээр өгүүлдэг [<https://>



Зураг 7. Үйс, хулс, яргай, зандан, шилбэн, бургас, тэнз, сүм зэрэг модоор хийсэн өнөө цагийн урт, богино ташуурууд



Зураг 8. а. Өндөр Хүрэнний оршуулгаас илэрсэн ташуурын сагалдаргын болон сурын уяа, б. өнөө үед ташуурын “зангиа” буюу сурыг модон ишинд хэд хэдэн янзаар холбож уясан нь

mongoltoli.mn/dictionary/detail/85891].

Ташуур хээрээс олбол сагалдаргыг дор нь хаядаг [Тангад 2014: 264], энхрий хүүхдийг говьд ургадаг сухай модоор ташуур хийж ташуурдах дом хэрэглэдэг [МУЗХСЭХ V, 2011: 42]. Мөн нас барсан хүний ташуурыг эмээлийн буруу талын ганзаганаас уяж, ламд барьдаг ажээ [МУЗХСЭХ V, 2011: 71].

Ташуур хэмээх үг орсон хэлц үг.

- ташуур алдам – маш их жавартай, хүйтэн
- ташуур өгөх – а. ташуурдах; б. ярианд хажуугаас нэмэр өгөх
- ташуур болох – хүчээ өргөж хамсаа болох ~ эрхэм ноён танд ташуур болж, насан туршдаа зүтгэхийг хүсэж байна.
- ташуур хөдөлгөлгүй – уриалгахны тухай ~ ташуур хөдөлгөлгүй ажлаа хийдэг хэдэн зарцтай болох юм сан.
- ядуу хүнд ноён олон, ядарсан моринд ташуур олон – ядарсан хүнийг дээрэлхэх хүн олон гэсэн санаа.
- хашин моринд ташуур олон, хажиг хүнд өстөн олон – а. ажил хэрэг сунжрах тусам шаардлага ихэсдэг; б. зан муутай хүнтэй нөхөрлөх хүн ховор гэсэн санаа [<https://mongoltoli.mn/dictionary/detail/85891>].

Дүгнэлт

Нүүдэлчид тэр дундаа монголчуудын агт морины тоног хэрэгслээс зөвхөн ташуурын талаар археологийн олдвор болон бусад лавлах хэрэглэгдэхүүнд тулгуурлан авч үзлээ. Одоогоор бидэнд байгаа материалаас үзэхэд эртний ташуурын мод хүннүгийн үеийн чулуун дарааст булшнаас 1, түрэгийн үед холбогдох хадны оршуулгаас 1, хятаны үеийн хадны оршуулгаас 4, монголын үеийн хадны оршуулгаас 3, нийт 9 хэрэглэгдэхүүн илэрч мэдэгдээд байна. Эдгээр олдворын уртын хэмжээг харьцуулж үзэхэд урт нь 1 м урттай, богино нь 30,8 см хэмжээтэй байна. 4 ташуурын мод урт ангилалд, 4 ташуурын мод дундаж ангилалд, 1 ташуурын мод богино ангилалд хамаарч байна.

Ташуурын ихэнхийг бургас модоор хийсэн ч яргай, сухайгаар хийсэн нь таарч байна. Дугуй Цахирын хадны оршуулгаас илэрсэн ташуурын модны бариулын хэсгийн төгсгөлийг гурвалжлан засаж, сагалдаргын оосор сүвлэн оруулах нэвт нүх гаргасан онцлогтой байна. Ташуурын модонд сагалдаргын нүхийг гаргахдаа эдүгээ цагийнхаас арай өөрөөр их дээгүүр үзүүр хэсэгт гаргажээ (зураг 2). Өөрөөр хэлбэл эрт үедээ сагалдаргын нүхийг ишинд гаргахдаа бариул хэсгийн үзүүрт нь тулгасан бол эдүгээ үед урт, богиноосоо шалтгаалж бариул хэсгээс 5-10 см доош зайд нэвт нүх гаргасан (зураг 7), сурын уяа, зангилаа

зэргийн ялгааг түүхэн цаг үеэр нь тодорхойлж, нүүдэлчдийн ташуурын хувьсал өөрчлөлтийг илүү нарийвчлах боломжтой юм.

Нүүдэлчид эрт цагт адууг унаж эдлэх болсонтой зэрэгцэн ташуурыг өргөн хэрэглэж ирснийг дээрх археологийн олдворуудаас гадна нүүдэлчин гарал угсаатай хятанчуудын бунхант оршуулгын ханын зураг, Эзэнт гүрний монголчуудтай холбогдох эртний Персийн номын чимэглэл зургийн дүрслэлээс харж болно. Тухайлбал, Хятаны үед ханын зураг бүхий бунхныг зөвхөн томоохон язгууртнуудад зориулж байгуулдаг бөгөөд Уухан хошууны нутгаас илэрсэн бунхны ханын зурагт эзнийхээ унааг бэлтгэсэн агтчин баруун гартаа барагцаагаар 1 м урттай ташуурыг барьсан байх ба ишний хоёр үзүүрт хөх өнгийн материалаар өргөн эмжсэн, сагалдаргын сурыг богино уяж, хоёр үзүүрийг унжуулсан байдлаар дүрсэлсэн (зураг 4а). Нөгөө хоёр зурагт мөн адил урт ташуурыг мөрөн дээрээ дамнуулан барьжээ (зураг 4б, 4в). Тиймээс олдвор болоод ханын зургаас үзэхэд Хятаны үед гоёж, чимсэн урт ташуурыг зэрэг зиндаа өндөртэй чинээлэг хэсгийнхэн тулхүү хэрэглэдэг байжээ гэж үзэх үндэстэй байна. Үүний зэрэгцээ энэ үеэс өмнө ч, энэ цаг үеэс хойш ч энгийн хүмүүс богино ташуурыг өдөр тутмын ердийн хэрэглээндээ өргөн хэрэглэж байсан нь мэдээж юм.

Монголын үед холбогдох хадны оршуулгын дурсгалаас 3 ташуурын мод илэрсэн нь бүгд дундаж ангилалд хамаарах бөгөөд сурын үлдэгдэлтэй байна. Харин Өндөр хүрэнний оршуулгаас илэрсэн ташуурын модонд сагалдаргын нүх гаргаагүй байх ба бариул хэсгийн үзүүрт нарийн хүзүүтэй булцуу маягийн “тээг” гаргаж түүнээсээ сагалдаргын сурыг уяж тогтоох зориулалттай хийжээ (зураг 2). Энэ үеийн ташуур өмнөх үед хамаарах ташуурын мод, сурын хийц, хэлбэр, хэмжээнээс өөрчлөгдсөн зүйлгүй тэр хэвээрээ уламжлагджээ. Эл саналыг бататгахад тэр үеийн судалгааны чухал хэрэглэгдэхүүн болох эртний Персийн миниатюрт угсаа гарал өндөртэй Монгол язгууртнуудыг ихэвчлэн нэгэн жигд өнгөтэй, урттай модоор хийсэн ташуурыг барьсан байдлаар дүрсэлсэн ба сурыг голдоо зангилаатайгаар дүрсэлжээ (зураг 6). Зургийн өгүүлэмжээс харахад морь унасан язгууртан баруун гартаа барьсан ташуураараа бусад руу дохиж зангасан, хагас өргөсөн ихэмсэг дээрэнгүй байдлаар дүрсэлжээ. Энэ нь тухайн үеийн Монголын эзэнт гүрний сүр хүчийг илтгэсэн агуулгатай ажээ. Харин дайн тулаанд оролцож буй дайчдыг бүгд богино ташууртайгаар дүрсэлжээ (зураг 5а-5г). Энэ нь аргагүй юм морьтон дайчид тэр олон зэр зэвсгийн хажуугаар дайсныг хөөж гүйцэх, ухран дутаан хурдлах үед моринд богино ташуур хэрэглэх нь (зураг 5) хамаагүй амар

хялбар байх нь ойлгомжтой. Богино ташуурыг аль ч цаг үед ердийн хэрэглээнд өргөн хэрэглэх боловч зарим тохиолдолд хашиж буй алба зэрэг ажил үүргийн онцлогоосоо шалтгаалж аян дайнд оролцож буй морьтон дайчдын гол хэрэглээ болж байжээ.

Түүнчлэн Монголын эзэнт гүрний үед эмээл, хазаар буюу агт морины тоног хэрэгсэл хийх албан газар хүртэл байгуулж байжээ. Тухайлбал, “Монголын захиргаанд байсан Хятадын засгийн газар: гарын авлагын лавлах” хэмээх номын 13.3.4-д Эмээлийн алба. Ch’eng an chu 成鞍局. Эмээлийн албан газар нь эзэн хааны зориулалтаар эмээл, хазаар, седан сандал үйлдвэрлэдэг байжээ. Энэ алба 1263 онд байгуулагдсан. Албан газар нь гурван захиралтай байжээ [Farquhar 1990: 100]. Мөн 13.3.5-д Ян Шань дахь эмээлийн алба. Yang shan an chu 羊山鞍局. Энэ газарт эмээл, хазаар үйлдвэрлэдэг. Албан газар 1281 онд байгуулагдсан бөгөөд нэг захирал, тоног хэрэгсэл хийх албатууд, нэг ахлахтай [Farquhar 1990: 101] хэмээн дурдсан байдаг. Үүнээс үзэхэд хаад, ноёдоос гадна төрийн өндөр алба эрхэлж буй язгууртан, онцгой гаяьяа байгуулсан дайчдыг хөхиүлэн шагнаж буй морины иж бүрэн тоног хэрэгсэлд ташуур ч бас багтаж байсан нь эргэлзээгүй.

Эндээс эцэст нь дүгнэж үзэхэд эртний оршуулгад талийгаачийн нөгөө ертөнц дэх амьдралд хэрэглэх морины тоног хэрэгсэл болгож эмээл, хазаар, дөрөө, ташуур зэргийг иж бүрэн хэрэгслийн хамт дагалдуулж тавьсан байх ба тухайн хүн амьд ахуйдаа ташуурыг зэрэг зиндаа, хашиж буй алба, оролцож буй баяр ёслол, найр наадамдаа тохируулан урт болон богино ташуурыг хэрэглэдэг заншилтай байжээ. Энэ заншил одоог хүртэл утга агуулгаа алдалгүй үргэлжилж буй бөгөөд Монголчуудын дунд яргай, сухай, бургас, тэнз, сүм зэрэг модоор хийсэн урт, богино ташуурыг (зураг 7) өргөн хэрэглэх ба олноо ховортой модоор иш хийж, үнэт төмөрлөгөөр бариул хэсгийг гоёмсог хээ чимэглэлээр эмжиж, бөгжилсөн гоёлын ташуурыг найр, наадамд түгээмэл хэрэглэдэг ёс алдагдаагүй уламжилсаар иржээ.

Ном зүй

Амартүвшин 2020 – Амартүвшин Ч., Батдалай Б. Хагтын хадны оршуулга. – Нүүдэлчдийн өв судлал. Tomus XXI-II, Fasc-11. УБ, Тал. 110-127.

Батсүх 2014 – Батсүх Д., Батбаяр Т. Жаргалант Хайрханы хадны оршуулга. Талын морьтон дайчдын өв соёл. (VII-XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн). УБ, Тал 207-241.

Баянтал 2021 – Баянтал Бай. Хятан бунхны ханын зураг. УБ, 2021.

Биргитт Хофманн 2005 – Биргитт Х. Ил хант улс – Монголчуудын байлдан дагууллаас Ил хант улсыг мөхөх (1220-1335) хүртэлх үеийн Ираны түүх, соёл. Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын Дэлхийн эзэнт гүрэн. – Эрдэм шинжилгээний каталоги. Бонн, Тал 244-293.

Birte Ahrens 2015 - Birte Ahrens, Gončigsüren Nomguunsüren, Henny Piezonka. Das mittelalterliche Höhlengrab von Cagaan Chad, Mongolei. Eine Kriegerbestattung am nördlichen Rand der Wüste Gobi. Zeitschrift für Archäologie des Mittelalters. Bonn, Pp. 59-126.

David M. Farquhar 1990 – David M. Farquhar. The Government of China under Mongolian rule. A Reference guide. Stuttgart, 1990.

Жангар 1963 – Жангарын тууль. Халимаг хэлнээс орчуулсан Т.Дүгэрсүрэн. УБ, 1963.

Cagaan Turbat 2012 – Cagaan Turbat, Dunburee Batsuch und Tomor-Ocir Batbajar. Das Felsgrab aus Conot uul, Bulgan sum, Chovd aймаг. Steppen Krieger. Reiternomaden des 7.-14. Jahrhunderts aus der Mongolei. Bonn, Pp. 267-284.

МУЗХСЭХ 2011 – Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. I-X боть. Эмхэтгэсэн С.Чулуун. УБ, 2011.

Тангад 2014 – Тангад Д. Монголын угсаатны зүйн судалгаа. I-IV боть. УБ.

Төрбат 2015 – Төрбат Ц., Батсүх Д., Бемманн Я. Монгол Алтайн өвөр бэлийн Авын хөх уулын хүннүгийн булш. – Studia Archaeologica. Tomus XXXV. Fasc-20. УБ, Тал. 295-323.

Эрдэнэбат 2005 – Эрдэнэбат У., Поол Э. Монгол орны хадны ангал, агуйн булш. Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын Дэлхийн эзэнт гүрэн. Эрдэм шинжилгээний каталоги. Бонн, 2005. Тал. 81-89.

Эрдэнэбат 2010 – Эрдэнэбат У., Амартүвшин Ч. Дугуй Цахирын хадны оршуулга (X-XII зуун). УБ, 2010.

Эрийн сайн Хан харангуй 1986 – Эрийн сайн Хан харангуй. УБ, 1986.

Энхтуяа 2017 – Энхтуяа Ш. Үзүүр Гялангийн олдворын бүртгэл. Хадан гэрийн соёл. УБ, Тал 36-55.

Энхбаатар 2020 – Энхбаатар М. Малын тоног хэрэгсэл. Аж ахуйн хэрэглээний толь. УБ, 2020.

몽골의 문화 유산 2010 – 몽골의 문화 유산 I. 대한민국의 문화재청 국립문화 연구소, 몽골 과학아카데미 고고학 연구소., 2010. Pp. 74-77

新疆洋海墓地 2019 – 编著 吐鲁番市文物局, 新疆文物考古研究所, 吐鲁番学研究院, 吐鲁番博物馆. 北京: 文物出版社, 2019.

<https://mongoltoli.mn/dictionary/detail/85891>

<https://images.is.ed.ac.uk/luna/servlet/workspace/>